

МҮХ-ийн Ерөнхий инженер Б.Сүхбаатарын Гамшигт өртөх эрсдэлийг бууруулах, цаг уурын мэдээлэл, эрт сэрэмжлүүлгийн системийн хэрэгсэл болон суралцаж буй мэдлэгээ төслийн санал болгоход ашиглах талаар нэмэлт санал бичих семинарын тайлан

2024.09.06

Сүүлийн жилүүдэд эдийн засаг хөгжиж, үйлдвэржилт ихсэхийн хэрээр дэлхийн хүн төрөлхтний агаар мандалд ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээ улам нэмэгдэж, үүнээс үүдэн агаарын температур дулаарсаар байна. Дэлхийн дулаарлын нөлөөнд улс орон бүр харилцан адилгүй өртөж байгаа хэдий ч болж буй байгалийн олон төрлийн гамшигт үзэгдлүүдийн давтамж, эрч хүч улам ширүүн догшин болж, нийгэм эдийн засагт учруулж буй хор уршиг хэдэн тэрбум америк доллараар хэмжигдэж байна. Иймд 2022 онд анх Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) “Эрт сэрэмжлүүлгийг хүн бүрд” санаачилгыг эхлүүлсэн бөгөөд 2027 он гэхэд энэхүү санаачилгын хүрээнд хүн бүр байгалийн аюул, гамшгаас бүрэн хамгаалагдах ёстой хэмээн цохон тэмдэглэсэн байдаг. Уг санаачилгыг бусад олон улсын байгууллагууд, ялангуяа дэлхийн цаг уурын байгууллага (ДЦУБ) дэмжиж, дэлхийн улс орнуудын эрт сэрэмжлүүлгийн системийг сайжруулах тал дээр дорвитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа юм. Энэхүү сэдвийн хүрээнд 2024 оны 8-р сарын 26-30-нд Солонгос Улсын Инчеон хотын Сонгдо дүүрэгт байрлах НҮБ-ын Гамшгийн Эрсдэлийг Бууруулах Газрын (UNDRR) Дэлхийн Боловсрол, Сургалтын Институт дээр “Гамшигт өртөх эрсдэлийг бууруулах, цаг уурын мэдээлэл, эрт сэрэмжлүүлгийн системийн хэрэгсэл (Монгол, Бутан улсын суралцагч нарын сургалт) болон суралцаж буй мэдлэгээ төслийн санал болгоход хэрэглэх талаар нэмэлт санал бичих семинар” зохион байгуулагдлаа. Семинарт Монгол, Бутан болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын нийт 23 мэргэжилтэн хамрагдсанаас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2, Цаг уур орчны шинжилгээний газраас 3, Сангийн яамнаас 1, Зориг сангаас 2, Онцгой байдлын ерөнхий газраас 4, Байгаль хамгаалах сангаас 2, Ус цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгээс 1, Нисэхийн цаг уурын төвөөс 1 мэргэжилтэн тус тус хамрагдав.

Семинарын зорилго

Семинарын гол зорилго нь Монгол, Бутан улсын олон төрлийн гамшигт өртөх эрсдэлийг бууруулах, цаг уурын мэдээлэл, эрт сэрэмжлүүлгийн системийн хэрэгсэл, технологийг ашиглах талаар мэдлэг, чадвараар хангах, мөн суралцаж буй мэдлэгээ үр дүнтэй төслийн санал болгоход хэрэглэх арга барилд суралцах явдал байлаа.

Уг зорилгын хүрээнд Монгол, Бутан, БНАЛАУ-ын мэргэжилтнүүд тухайн улс орнуудад элбэг тохиолдож буй байгалийн аюулт болон гамшигт үзэгдлийн талаарх танилцуулгыг хийж, улс орон бүр тэдгээр гамшгаас хэрхэн урьдчилан сэрэмжлүүлж буй систем, арга технологийг танилцуулсан юм. Ингэснээр тухайн улс орнууд хоорондоо сайн туршлага солилцох, дутмаг байгаа тал дээр илүү нягт хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн.

Семинарын үндсэн агуулга

Семинарын үед дараах сэдвүүдийг авч хэлэлцсэн:

- Гамшигт өртөх эрсдэлийг бууруулах, цаг уурын мэдээлэл, эрт сэрэмжлүүлгийн системийн хэрэгсэл, технологийг танилцуулах
- Эдгээр хэрэгсэл, технологийг ашиглах арга барил, давуу талыг тайлбарлах
- Төслийн санал бичих үндсэн зарчим, аргачлалыг заах
- Төслийн саналыг хэрхэн үр дүнтэй бичих, хэрэгжүүлэх талаар зөвлөгөө өгөх
- Уур амьсгалын ногоон сан (GCF)-аас хэрхэн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах төслүүдийг бичиж сурах, цаашид төсөл боловсруулж өргөн барих

Семинарын үр дүн

8 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн хүрээ 2030 баримт бичигт тусгагдсан гамшгийн эрсдэлийг бууруулахад авах арга хэмжээний талаарх гол ойлголтуудын онолын хичээлийг үзэж судалсан. 28-30-ны өдрүүдэд уур амьсгалын ногоон сангаас зохион байгуулсан өмнөх өдрүүдэд үзсэн онолын хичээл дээр тулгуурлаж төслийн санал хэрхэн гаргах, тухайн төслийг цаашид хэрхэн өргөн барих талаар сургалтад оролцогчид нийт 5, Монгол улсын оролцогчид 4 багт хуваагдаж ажилласан. Ингэхдээ баг тус бүр уур амьсгалын ногоон сангаас өгсөн төслийн форматын дагуу тухайн улс оронд олон төрлийн аюул гамшгаас эрт сэрэмжлүүлэхэд техник технологийн хувьд хаана илүү дутагдалтай байгааг асуумжаар үнэлж, гарч ирсэн үр дүнд тулгуурлан хэрэгжүүлэх төслийн санаануудыг гаргаж ажилласан. Монгол орны хувьд сүүлийн жилүүдэд цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн давтамж ихсэж, ялангуяа хот суурин газарт үерийн аюул нүүрлэж байгаатай холбоотойгоор хотын болон зорилтот бүлгийн (хараа, сонсголын бэрхшээлтэй, хүүхэд г.м) иргэдэд олон төрлийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг цаг алдалгүй, хурдан шуурхай хүргэхэд чиглэсэн төслийн ажлуудын санал ихэнх хувийг эзэлж байв. Миний хувьд Монголын 3-р багт хуваарилагдсан ба цаг уурын автомат станцыг нэмэгдүүлэх, уулын өндөрлөгүүдэд автомат станц суурилуулах, хиймэл дагуулын мэдээний ашиглалтыг нэмэгдүүлж үүлний төрлийг ялгах, цаг уурын радарын ажиглалтгүй хэсгийн орон зайд үүлний орны тухай дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх гэсэн саналыг бичсэн. Ингэснээр цаг уурын урьдчилсан мэдээг гаргаж буй инженерүүдийн ашиглаж буй мэдээ сайжирч, гамшигт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, түүнээс сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авах боломжийг бүрдүүлэх зорилготой юм.

Дүгнэлт

Энэхүү семинар нь Монгол, Бутан улсын гамшгийн эрсдэлийн бэлэн байдлыг хангах чиглэлээр чухал алхам болсон бөгөөд оролцогчдын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Ялангуяа гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах чиглэлээр одоо авч хэрэгжүүлж буй арга хэмжээг цаашид илүү нарийн болгож, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулахад чухал үүрэгтэй байлаа. Цаашид энэхүү туршлагыг үндэслэн сургалтад оролцсон холбогдох байгууллагууд хамтран ажиллаж, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр үр дүнтэй ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай юм.

Хавсралт



1. Сургалтад хамрагдсан нийт оролцогсдын групп зураг



2. Монгол орны эрт сэрэмжлүүлгийн системийн талаарх танилцуулга (ЦУОШГ)



3. Ноён Санжаяа Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард улсад хэрэгжүүлсэн эрт сэрэмжлүүлгийн системийн талаарх туршлагаасаа хуваалцаж буй нь